



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/31

Сүмбэр сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний хаагчдын ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01/1457 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулаг “Ёс зүйн дэд” хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс дэд хорооны дарга : Б.Аюушжав Нийгмийн хамгааллын байцаагч

Ёс зүйн дэд хорооны гишүүд: А.Мягмаржамц Сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан, сүлжээний инженер

Ч.Буянхишиг Төлөвлөлт, нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: Б.Жавзан Хүний нөөц, бичиг хэрэг, архив, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар баталсан “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгааллын байцаагч /Б.Аюушжав/-д үүрэг болгосугай.

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
О.БАЙГАЛЬСАЙХАН



422300063